



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/131

Арвайхээр

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1}, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумдын салбар комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн ажлын хэсгийн дарга (И.Доржсүрэн)-д даалгах нь:

-Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг оновчтой зохион байгуулж, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах.

-Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг саатуулсан, зайлсхийсэн буруутай албан тушаалтан, иргэнд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах.

-Тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, жолоочийн даатгалд даатгуулаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар төрийн холбогдох байгууллагуудад үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3. Сумдын Засаг дарга нар болон сумдын салбар ажлын хэсгийн ахлагч нарт ДААЛГАХ нь:

-Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөрийн аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт бүрэн шилжүүлж, татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

-Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

011100296

2.

-Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харъяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2019 оны 03
дугаар сарын 11-ны өдрийн 11/131 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ,
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН


Комиссын дарга: И.Доржсүрэн -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга З.Балданням -Аймгийн Автотээврийн төвийн дарга

Гишүүд: Н.Эрдэнэсүвд -Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга

- Б.Бүрэнтөгс -Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга
- С.Дуламсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Б.Цэндсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч
- Б.Мөнхбат -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2019 оны .03.
дугаар сарын .11.-ны өдрийн 1131 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт




ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ,
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ СУМДЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга -Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: -Сумын хэсгийн төлөөлөгч болон цагдаагийн ажилтан.
-Татварын байцаагч
- Багийн Засаг дарга нар

Аймгийн Засаг даргын 2019 оны . 03
 дугаар сарын . 11-ны өдрийн /11/ дугаар
 захирамжийн гуравдугаар хавсралт



СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Сумдын нэрс	хугацаа	Хоног	Ажлын бүрэлдэхүүн
1	Арвайхээр	1 дүгээр сарын 2-ноос 4 сарын 7		ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
2	Есөнзүйл	4 дүгээр сарын 8, 9	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
3	Өлзий	4 дүгээр сарын 10, 11	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
4	Баян-Өндөр	4 дүгээр сарын 12,13, 14	3	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
5	Сант	4 дүгээр сарын 15, 16, 17	3	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
6	Баянгол	4 дүгээр сарын 18, 19	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
7	Төгрөг	4 дүгээр сарын 20, 21	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
8	Гучин-Ус	4 дүгээр сарын 22, 23	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
9	Богд	4 дүгээр сарын 24, 25, 26	3	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
10	Баруунбаян-Улаан	4 дүгээр сарын 27, 28	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
11	Баянтээг баг	4 дүгээр сарын 29, 30	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
12	Нарийнтээл	5 дугаар сарын 1, 2	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
13	Хайрхандулаан	5 дугаар сарын 3, 4	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
14	Тарагт	5 дугаар сарын 5, 6	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс

15	Бүрд	5 дугаар сарын 7,8	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
16	Жаргалант баг	5 дугаар сарын 12, 13	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
17	Уянга	5 дугаар сарын 14, 15, 16, 17, 18	5	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
18	Бат-өлзий	5 дугаар сарын 19, 20, 21, 22, 23, 24	6	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
19	Хужирт	5 дугаар сарын 25, 26, 27, 28, 29	5	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
20	Хархорин	5 дугаар сарын 30, 31 6 дугаар сарын 2, 3, 04, 5, 6, 7, 6 дугаар сарын 9, 10.11	11	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
21	Зүүнбаян-улаан	6 дугаар сарын 12.13	2	ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс
22	Арвайхээр	6 дугаар сарын 17-ноос 12 дугаар сарын 25-нийг дуустал		ӨВ Автотээврийн төв, ӨВ аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс